



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор аймгийн Байгаль орчны газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БНА-2025/123/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Баянхонгор
2025 оны 02 дугаар сарын 12

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат
Утас: 70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn
Аудитын менежер: М.Алтантуяа
Утас: 80112188 Цахим хаяг: altantuyam@audit.gov.mn
Ахлах аудитор: Н.Батчимэг
Утас: 91113253 Цахим хаяг: batchimegn@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ.....	2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	7
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	14
4. АУДИТЫН ТАЙЛАН	19
4.1 Ерөнхий зүйл.....	19
4.2 Материаллаг байдал.....	19
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	20
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	20
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	20
4.5.1 Завсрын аудитын талаар.....	20
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	21
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	22

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101
Утас: (976) 70442584

Цахим шуудан: procurement_bayankhongor@audit.gov.mn

2025.02.12 № 2/10
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Байгаль орчны газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор аймгийн Байгаль орчны газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар тодорхой бус байдал нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

5020137

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Баянхонгор аймгийн Байгаль орчны газрын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 13 зорилтын хүрээнд 68 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг аймгийн ЗДТГ-ын Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэс 91.2 хувиар үнэлсэн байна.

Баянхонгор аймгийн Байгаль орчны газрын 2024 оны санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

Б.МӨНХБАТ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>678,652,385.35</u>	<u>855,249,361.28</u>
33	АВЛАГА	134,185,644.84	429,744,069.27
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	726,644.84	241,069.27
335	Бусад авлага	133,459,000.00	429,503,000.00
3351	Байгууллагаас авах авлага	133,459,000.00	429,503,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	292,399,762.51	218,146,314.01
351	Түүхий эд материал	178,770,495.01	160,925,495.01
35110	Тусгай зориулалттай материал	178,770,495.01	160,925,495.01
354	Хангамжийн материал	113,629,267.50	57,220,819.00
35410	Бичиг хэргийн материал	1,265,000.00	1,810,800.00
35420	Аж ахуйн материал	21,463,530.00	18,806,180.00
35430	Сэлбэг хэрэгсэл	3,835,300.00	00.00
35440	Түлш, шатах тослох материал	8,441.00	236,239.00
35450	Барилгын засварын материал	974,000.00	974,000.00
35470	Бусад хангамжийн материал	86,082,996.50	35,393,600.00
36	НӨӨЦИЙН БАРАА	252,066,978.00	207,358,978.00
36100	Барааны нөөц	252,066,978.00	207,358,978.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>861,197,667.82</u>	<u>924,203,500.71</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	861,197,667.82	924,203,500.71
392	Биет хөрөнгө	448,522,084.45	471,406,250.78
39201	Барилга, байгууламж, орон сууц	267,386,709.12	267,386,709.12
39202	Хуримтлагдсан элэгдэл	-31,387,212.88	-39,359,432.80
39203	Авто-тээврийн хэрэгсэл	149,350,000.00	69,350,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-99,129,166.39	-45,374,999.90
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	152,798,111.45	275,894,766.66
39206	Хуримтлагдсан элэгдэл	-45,054,005.33	-101,990,822.88
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	41,275,550.00	43,085,550.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-20,797,663.44	-27,196,233.92
39214	Бусад үндсэн хөрөнгө	45,950,000.00	45,950,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-11,870,238.08	-16,339,285.50
393	Биет бус хөрөнгө	412,675,583.37	452,797,249.93
39301	Програм хангамж	7,935,000.00	7,935,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-4,742,749.89	-7,329,083.29
39303	Бусад биет бус хөрөнгө	413,150,000.00	457,858,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-3,666,666.74	-5,666,666.78
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,539,850,053.17</u>	<u>1,779,452,861.99</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>00.00</u>	<u>9,000,982.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	00.00	9,000,982.00
413	Өглөг	00.00	9,000,982.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	00.00	982.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	00.00	9,000,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,539,850,053.17</u>	<u>1,770,451,879.99</u>

Баянхонгор аймгийн Байгаль орчны газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

51	Засгийн газрын хувь оролцоо	1,539,850,053.17	1,770,451,879.99
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	252,228,714.62	252,228,714.62
51101	Өмч: - төрийн	252,228,714.62	252,228,714.62
512	Хуримтлагдсан үр дүн	1,096,826,172.15	1,327,427,998.97
51210	Өмнөх үеийн үр дүн	1,096,826,172.15	1,096,826,172.15
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	230,601,826.82
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	190,795,166.40	190,795,166.40
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>1,539,850,053.17</u>	<u>1,779,452,861.99</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,866,634,333.26	2,667,514,445.21
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	252,226,260.26	91,146,881.21
120	Нийтлэг татварын бус орлого	252,226,260.26	91,146,881.21
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	350,000.00	350,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	350,000.00	350,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,614,408,073.00	2,576,367,564.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	494,296,473.00	951,136,164.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	29,614,973.00	284,463,164.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	464,681,500.00	666,673,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,120,111,600.00	1,625,231,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,120,111,600.00	1,625,231,400.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,605,969,671.66	2,477,176,173.87
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,605,969,671.66	2,477,176,173.87
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,574,322,685.38	2,328,088,945.86
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	767,568,333.59	1,125,927,912.00
210101	Үндсэн цалин	440,207,084.84	639,892,193.43
210102	Нэмэгдэл	256,609,548.75	375,785,224.13
210103	Унаа хоолны хөнгөлөлт	42,471,000.00	57,586,370.00
210104	Урамшуулал	00.00	52,664,124.44
210105	Гэрээт ажлын хөлс	28,280,700.00	00.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	94,910,564.75	136,782,288.76
210201	Тэтгэврийн даатгал	65,260,671.55	94,375,873.19
210202	Тэтгэмжийн даатгал	7,675,145.63	11,265,266.10
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,140,116.55	5,711,650.33
210204	Ажилгүйдлийн даатгал	1,439,508.25	5,085,898.06
210205	Эрүүл мэндийн даатгал	14,395,122.77	20,343,601.08
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	22,672,130.61	26,017,010.80
210301	Гэрэл, цахилгаан	3,329,871.85	3,190,556.60

Баянхонгор аймгийн Байгаль орчны газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210302	Түлш, халаалт	17,344,800.76	20,856,398.20
210303	Цэвэр, бохир ус	1,997,458.00	1,970,056.00
2104	Хангамж, бараа материалын зардал	118,138,862.13	108,924,013.50
210401	Бичиг хэрэг	5,715,882.40	7,948,700.00
210402	Тээвэр, шатахуун	11,842,498.00	16,340,843.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,057,178.36	2,124,574.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,200,000.00	1,200,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,273,303.37	7,904,100.00
210408	Бараа материал акталсны зардал	00.00	73,405,796.50
210409	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн /ТӨҮГ/	94,050,000.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,383,500.00	16,799,100.00
210604	Урсгал засвар	4,383,500.00	16,799,100.00
2107	Томилолт, зочны зардал	12,908,200.00	12,350,000.00
210702	Дотоод албан томилолт	12,908,200.00	12,350,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	404,466,574.00	440,937,544.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	402,446,034.00	438,753,908.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	300,000.00	450,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	300,000.00	300,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	526,232.00	327,224.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	00.00	22,000.00
210807	Газрын төлбөр	894,308.00	1,084,412.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	149,274,520.30	460,351,076.80
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	73,808,704.00	357,586,699.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	666,900.00	600,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	74,798,916.30	102,164,377.80
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	31,646,986.28	149,087,228.01
2132	Бусад урсгал шилжүүлэг	26,755,700.00	110,476,883.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	22,278,700.00	15,426,600.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	00.00	91,080,283.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,477,000.00	3,970,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	4,891,286.28	38,610,345.01
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,891,286.28	38,610,345.01
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>260,664,661.60</u>	<u>190,338,271.34</u>
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	00.00	44,708,000.00
145002	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз	00.00	44,708,000.00
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	122,998.00	4,444,444.52
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	122,998.00	4,444,444.52
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-122,998.00	40,263,555.48
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>260,541,663.60</u>	<u>230,601,826.82</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>1,614,758,073.00</u>	<u>2,710,176,564.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	350,000.00	350,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	350,000.00	350,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	350,000.00	350,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	350,000.00	350,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,614,408,073.00	2,709,826,564.00
131009	Оны эхний үлдэгдлээс санхүүжих	00.00	133,459,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	494,296,473.00	951,136,164.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	29,614,973.00	284,463,164.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	464,681,500.00	666,673,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,120,111,600.00	1,625,231,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,120,111,600.00	1,625,231,400.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>1,614,318,073.00</u>	<u>2,675,804,564.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,614,318,073.00	2,675,804,564.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,449,212,086.72	2,097,214,335.99
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	767,624,563.25	1,125,360,521.13
210101	Үндсэн цалин	440,263,314.50	639,324,802.56
210102	Нэмэгдэл	256,609,548.75	375,785,224.13
210103	Унаа хоолны хөнгөлөлт	42,471,000.00	57,586,370.00
210104	Урамшуулал	00.00	52,664,124.44
210105	Гэрээт ажлын хөлс	28,280,700.00	00.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	94,957,384.50	136,899,536.06
210201	Тэтгэврийн даатгал	65,307,491.30	94,493,120.49
210202	Тэтгэмжийн даатгал	7,675,145.63	11,265,266.10
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,140,116.55	5,711,650.33
210204	Ажилгүйдлийн даатгал	1,439,508.25	5,085,898.06
210205	Эрүүл мэндийн даатгал	14,395,122.77	20,343,601.08
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	22,672,130.61	26,017,010.80
210301	Гэрэл, цахилгаан	3,329,871.85	3,190,556.60
210302	Түлш, халаалт	17,344,800.76	20,856,398.20
210303	Цэвэр, бохир ус	1,997,458.00	1,970,056.00
2104	Хангамж, бараа материалын зардал	22,156,361.36	21,349,574.00
210401	Бичиг хэрэг	5,547,882.40	4,450,000.00
210402	Тээвэр, шатахуун	10,250,000.00	10,000,000.00

Баянхонгор аймгийн Байгаль орчны газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан			
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,049,978.96	2,199,574.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,200,000.00	1,200,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,108,500.00	3,500,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,707,000.00	14,728,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	300,000.00	38,000.00
210602	Тавилга	00.00	190,000.00
210604	Урсгал засвар	8,407,000.00	14,500,000.00
2107	Томилолт, зочны зардал	12,908,200.00	6,190,000.00
210702	Дотоод албан томилолт	12,908,200.00	6,190,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	374,245,547.00	441,889,080.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	372,225,007.00	439,705,444.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	300,000.00	450,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	300,000.00	300,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	526,232.00	327,224.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	00.00	22,000.00
210807	Газрын төлбөр	894,308.00	1,084,412.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	145,940,900.00	324,780,614.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	145,208,000.00	324,180,614.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	732,900.00	600,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	165,105,986.28	578,590,228.01
2132	Бусад урсгал шилжүүлэг	26,755,700.00	110,476,883.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	22,278,700.00	15,426,600.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	00.00	91,080,283.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,477,000.00	3,970,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	138,350,286.28	468,113,345.01
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,891,286.28	38,610,345.01
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>440,000.00</u>	<u>34,372,000.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	440,000.00	34,372,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	440,000.00	34,372,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	440,000.00	34,372,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	440,000.00	34,372,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-440,000.00</u>	<u>-34,372,000.00</u>

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан (төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	252,228,714.62	192,131,674.55	834,948,000.40	00.00	1,279,308,389.57
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	1,336,508.15	00.00	1,336,508.15
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	252,228,714.62	192,131,674.55	836,284,508.55	00.00	1,280,644,897.72
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	260,541,663.60	00.00	260,541,663.60
C08	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	252,228,714.62	190,795,166.40	1,096,826,172.15	00.00	1,539,850,053.17
D01	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	252,228,714.62	190,795,166.40	1,096,826,172.15	00.00	1,539,850,053.17
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	252,228,714.62	190,795,166.40	1,096,826,172.15	00.00	1,539,850,053.17
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	230,601,826.82	00.00	230,601,826.82
D09	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	252,228,714.62	190,795,166.40	1,327,427,998.97	00.00	1,770,451,879.99

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан (төгрөгөөр)

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,626,231,400.00	1,588,474,105.99	37,757,294.01	97.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,626,231,400.00	1,588,474,105.99	37,757,294.01	97.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,590,456,500.00	1,569,077,505.99	21,378,994.01	98.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,125,626,500.00	1,125,360,521.13	265,978.87	100.0
210101	Үндсэн цалин	639,590,781.43	639,324,802.56	265,978.87	100.0
210102	Нэмэгдэл	375,785,224.13	375,785,224.13	0.00	100.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	57,586,370.00	57,586,370.00	0.00	100.0
210104	Урамшуулал	52,664,124.44	52,664,124.44	0.00	100.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	140,703,300.00	136,899,536.06	3,803,763.94	97.3
210201	Тэтгэврийн даатгал	95,678,300.00	94,493,120.49	1,185,179.51	98.8
210202	Тэтгэмжийн даатгал	11,256,300.00	11,265,266.10	-8,966.10	100.1
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,628,000.00	5,711,650.33	-83,650.33	101.5
210204	Ажилгүйдлийн даатгал	5,628,200.00	5,085,898.06	542,301.94	90.4
210205	Эрүүл мэндийн даатгал	22,512,500.00	20,343,601.08	2,168,898.92	90.4
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	26,531,900.00	26,017,010.80	514,889.20	98.1
210301	Гэрэл, цахилгаан	3,500,000.00	3,190,556.60	309,443.40	91.2
210302	Түлш, халаалт	21,031,900.00	20,856,398.20	175,501.80	99.2
210303	Цэвэр, бохир ус	2,000,000.00	1,970,056.00	29,944.00	98.5
2104	Хангамж, бараа материалын зардал	21,350,000.00	21,349,574.00	426.00	100.0
210401	Бичиг хэрэг	4,450,000.00	4,450,000.00	0.00	100.0
210402	Тээвэр, шатахуун	10,000,000.00	10,000,000.00	0.00	100.0

Баянхонгор аймгийн Байгаль орчны газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,200,000.00	2,199,574.00	426.00	100.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,200,000.00	1,200,000.00	0.00	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,500,000.00	3,500,000.00	0.00	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	29,100,000.00	29,100,000.00	0.00	100.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	12,600,000.00	12,600,000.00	0.00	100.0
210602	Тавилга	2,000,000.00	2,000,000.00	0.00	100.0
210604	Урсгал засвар	14,500,000.00	14,500,000.00	0.00	100.0
2107	Томилолт, зочны зардал	6,200,000.00	6,190,000.00	10,000.00	99.8
210702	Дотоод албан томилолт	6,200,000.00	6,190,000.00	10,000.00	99.8
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	12,844,800.00	12,837,250.00	7,550.00	99.9
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	10,660,800.00	10,653,614.00	7,186.00	99.9
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	450,000.00	450,000.00	0.00	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	300,000.00	300,000.00	0.00	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	327,500.00	327,224.00	276.00	99.9
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	22,000.00	0.00	100.0
210807	Газрын төлбөр	1,084,500.00	1,084,412.00	88.00	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	228,100,000.00	211,323,614.00	16,776,386.00	92.6
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	227,500,000.00	210,723,614.00	16,776,386.00	92.6
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	600,000.00	600,000.00	0.00	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	35,774,900.00	19,396,600.00	16,378,300.00	54.2
2132	Бусад урсгал шилжүүлэг	35,774,900.00	19,396,600.00	16,378,300.00	54.2
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	31,774,900.00	15,426,600.00	16,348,300.00	48.5
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,000,000.00	3,970,000.00	30,000.00	99.3
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,668,035,800.00	1,625,581,400.00	42,454,400.00	97.5
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,667,035,800.00	1,625,231,400.00	41,804,400.00	97.5
132001	Орон нутгийн төсвөөс	1,667,035,800.00	1,625,231,400.00	41,804,400.00	97.5
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	1,000,000.00	350,000.00	650,000.00	35.0
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,000,000.00	350,000.00	650,000.00	35.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан (төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	653,589,113.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	653,589,113.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	562,508,830.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	429,051,830.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	429,051,830.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	133457000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	133,457,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	91080283.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	91,080,283.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	91,080,283.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	951136164.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	951,136,164.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	284,463,164.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	666,673,000.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Баянхонгор аймгийн Байгаль орчны газар нь байгаль орчны чиглэлийн хууль тогтоомжийг харьяа нутаг дэвсгэртээ хэрэгжүүлэх, байгаль хамгаалах, байгалийн баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх, байгаль орчны мэдээллийн сан бүрдүүлэх, байгаль орчин, ногоон хөгжлийн сургалт, судалгаа, сурталчилгааны ажлыг гүйцэтгэдэг аймгийн Засаг даргын харьяаны байгууллага юм.

Баянхонгор аймгийн Байгаль орчны газар нь 2024 онд гүйцэтгэлийн төлөвлөгөөнд “бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт арга, хэмжээ”-г хэрэгжүүлэх хүрээнд 7 зорилт 46 арга хэмжээ, “төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах” хүрээнд 2 зорилт 6 арга хэмжээ, “хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх” хүрээнд 3 зорилт 6 арга, хэмжээ, “хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх” хүрээнд 3 зорилт 10 арга, хэмжээ нийт 13 зорилт 68 арга хэмжээг тусгасан байна.

Тайлант онд хөрөнгө захиран зарцуулах 1 дүгээр гарын үсгийг Дарга Э.Ганзориг (2024.01.01-2024.04.24, 2024.11.25-2024.12.31), Д.Содномсамдан (2024.04.24-2024.11.25), 2 дугаар гарын үсгийг ерөнхий нягтлан бодогч Л.Доржханд нар зурж, нярваар Б.Хажидсүрэн ажиллажээ.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна.

- Монгол Улсын Засгийн газрын 2024 оны “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 128 дугаар тогтоол
- Монгол Улсын Засгийн газрын 2024 оны “Тогтоолын хавсралт өөрчлөн батлах тухай” 82 дугаар тогтоол (Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид орон нутагт ажилласны нэмэгдэл олгох журам)
- Монгол Улсын Засгийн газрын 2024 оны “Журам батлах, журмын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” 83 дугаар тогтоол (Төрийн захиргааны албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам)

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүргийг Баянхонгор аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба хэрэгжүүлдэг ба санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор аймгийн Байгаль орчны газар нь 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын үйл ажиллагаандаа мөрддөг Баянхонгор аймгийн төсвийн байгууллага, төсөл сангийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан бэлтгэхэд мөрдөх “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын жишиг баримт бичиг” нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баянхонгор аймгийн Байгаль орчны газар нь 2024 оны санхүүгийн тайланг УСНББОУС-1 стандартын дагуу бэлтгэсэн байна.

Баянхонгор аймгийн Байгаль орчны газрын 2024 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгө 1,779,452.9 мянган төгрөг байгаа бөгөөд өмнөх оноос 239,602.8 мянган төгрөгөөр буюу 13.5 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт (мянган төгрөгөөр)

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	0.0	0.0	0.0
Авлага	134,185.6	429,744.1	259,558.5
Бараа материал	292,399.8	218,146.3	(74,253.5)
Нөөцийн бараа	252,067.0	207,359.0	(44,708.0)
Үндсэн хөрөнгө	1,077,845.4	1,167,460.0	89,614.4
Хуримтлагдсан элэгдэл	(216,647.7)	(243,256.5)	(26,608.8)
Нийт хөрөнгө	1,539,850.1	1,779,452.9	239,602.8
Өр төлбөр	0.0	9,001.0	9,001.0
Засгийн газрын хувь оролцоо (Эздийн өмч)	1,539,850.1	1,770,451.9	239,601.8
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,539,850.1	1,779,452.9	239,602.8

Авлагын дансны эхний үлдэгдэл 134,185.6 мянган төгрөгөөс төлбөртэй үйлчилгээний авлага 133,459.0 мянган төгрөгийг барагдуулж, тайлант оны эцэст 429,744.1 мянган төгрөг авлагын үлдэгдэлтэй байгаа нь ажиллагсадтай холбоотой 241.1 мянган төгрөгийн авлага, оны эцэст орон нутагт төвлөрүүлсэн шонхрын хураамжийн авлага 167,130.0 мянга, ангын дуудлага худалдааны орлогоос орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн 262,373.0 мянган төгрөгийн авлага үүссэнтэй холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 218,146.3 мянган төгрөг болж өмнөх оноос 74,253.5 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд төсвийн хөрөнгөөр 99,875.5 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, "Ник" ХХК-аас 262.2 мянган төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүй шилжүүлэн авч, даргын 2024.06.06-ны өдрийн А/21 дүгээр тушаалаар 73,405.8 мянган төгрөгийн хөрөнгийг акталж, үйл ажиллагаандаа 100,985.3 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсантай холбоотой байна.

Нөөц бараа дансны үлдэгдэл 207,359.0 мянган төгрөг болж өмнөх оноос 44,708.0 мянган төгрөгөөр буурсан нь ан агнуурын менежментийн төлөвлөгөөг үндсэн хөрөнгийн дансанд шилжүүлэн бүртгэсэнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 924,203.5 мянган төгрөг болж 63,005.8 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 34,372.0 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авсан, нөөцийн бараа дансанд бүртгэлтэй 44,708.0 мянган төгрөгийн ан агнуурын менежментийн төлөвлөгөөг бусад үндсэн хөрөнгө дансанд, төслийн хөрөнгөөр үнэ төлбөргүй нийлүүлэгдсэн 90,534.6 мянган төгрөгийн хөрөнгийг тоног төхөөрөмж дансанд бүртгэж, аймгийн ИТХ-ын даргын 2024.05.30-ны өдрийн 40 дүгээр захирамжаар 80,000.0 мянган төгрөгийн автомашиныг дуудлага худалдаагаар худалдаж данснаас хассантай холбоотой байна.

Тайлант оны эцэст 9,001.0 мянган төгрөгийн өглөгтэй байгаа нь үйлдвэрчний эвлэлийн татварын 1.0 мянга, мазаалайн хөв цөөрөм байгуулах биотехникийн арга хэмжээний үлдэгдэл санхүүжилт 9,000.0 мянган төгрөгийн өртэй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл тайлант үеийн үр дүнгийн 230,601.8 мянган төгрөгөөр өсөж 1,779,452.9 мянган төгрөг болсон байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 3,122,082.7 мянга, өөрийн үндсэн үйл ажиллагааны орлогоос 0.7 мянга нийт 3,122,083.4 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр, нийт зарлагыг 3,122,083.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг 1 удаа тодотгон 13,204.4 мянган төгрөгөөр бууруулан орон нутгийн төсвөөс 1,625,231.4 мянга, өөрийн үйл ажиллагааны орлого 1,000.0 мянган нийт 1,626,231.4 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр орон нутгийн төсвөөс 1,625,231.4 мянга, өөрийн үйл ажиллагааны орлого 1,000.0 мянган нийт 1,626,231.4 мянган санхүүжүүлэхээр төлөвлөж гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 1,625,231.4 мянга, өөрийн үйл ажиллагааны орлогоос 350.0 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж нийт 1,625,581.4 мянган төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Орон нутгийн төсвийн зардлын гүйцэтгэл 1,588,124.1 мянган төгрөг буюу 97.7 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 37,107.3 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

(мянган төгрөгөөр)

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
	71413 Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх	1,625,231.4	1,588,124.1	37,107.3	97.7
1	80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	1,351,295.7	1,347,350.3	3,945.4	99.7
2	80205 Мэдээлэл, сурталчилгааны зардал	1,585.8	1,585.8	0.0	100.0
3	80219 Харуул, хамгаалалтын зардал	9,075.0	9,067.8	7.2	99.9
4	80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	35,774.9	19,396.6	16,378.3	54.2
5	81701 Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардал	227,500.0	210,723.6	16,776.4	92.6

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд тус байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансаар дараах орлого төвлөрсөн байна. (мянган төгрөг)

№	Орлогын төрөл	Санхүүжилтийн дүн	Зарцуулсан	Төвлөрүүлсэн
1	Аймгийн Засаг даргын 2024 оны А/108 дугаар захирамжийн дагуу өмнөх оны зарцуулагдаагүй орлого хуваарилсан (дуудлага худалдааны орлого)	133,459.0	133,457.0	-
2	Төрийн захиргааны албан хаагчдад 5 жил тутам олгох тэтгэмж	91,080.3	91,080.3	-
3	Аймгийн ИТХ-ын даргын 2024 оны А/30, А/31 дүгээр захирамжийн дагуу гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд өгсөн санхүүжилт	5,917.0	5,917.0	-
4	Ойн газраас орон нутагт цэцэрлэгт хүрээлэн байгуулах ажлын санхүүжилт	187,185.9	187,179.8	Орон нутгийн төсөвт 6.1 мянган төгрөг төвлөрүүлсэн
5	Ангийн дуудлага худалдааны орлого	498,328.0	-	Улсын төсөвт 235,955.0 мянга, орон нутгийн төсөвт 262,373.0 мянга
6	Тендерийн орлого	280.0	-	Орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн
7	Шонхорын хураамж	168,345.0	1,215.0	Орон нутгийн төсөвт 167,130.0 мянган төгрөгийг төвлөрүүлсэн
8	Дэнчингийн мөнгө	41,990.0	41,990.0	Иргэдэд буцаан олгосон
9	Зөвшөөрлийн үнэ	425.0	425.0	Байгаль орчин уур амьсгалын санд шилжүүлсэн.
-		1,127,010.2	696,004.1	

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

Монгол Улсын Засгийн газрын 2024.03.06-ны өдрийн “Тусгай зориулалтаар 2024 онд агнах, барих агнуурын амьтны тоо хэмжээг тогтоох тухай” 89 дүгээр тогтоолоор Баянхонгор аймагт угалз-8, тэх-24, халиун буга-3 агнах шийдвэр гарч угалз-8, тэх-23, халиун буга-3 агнасан байна. Мөн 2024 онд 130 идлэг шонхор агнаж 168,345.0 мянга, ангийн дуудлага худалдааны орлогоос 498,328.0 мянган төгрөг төвлөрсөн байна.

Дэнчингийн орлогоос 41,990.0 мянган төгрөг төвлөрснийг буцаан олгож орон нутгийн төсөвт 431,006.1 мянган төгрөгийн төвлөрүүлсэн байна.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Ойн газраас эрх шилжиж ирсэн Баянхонгор аймгийн Бууцагаан сумын цэцэрлэгт хүрээлэнд мод сөөг суулгах 187,200.0 мянган төгрөгийн 1 худалдан авах ажиллагааг төлөвлөж нээлттэй тендер шалгаруулалт зохион байгуулж “Түйн голын төгөл” ХХК-тай 187,179.8 мянган төгрөгийн гэрээ байгуулж санхүүжилтийг бүрэн олгосон байна.

Тус байгууллага нь түлш халаалтын зардалд 21,031.9 мянга, гэрэл цахилгааны зардалд 3,500.0 мянга, цэвэр, бохир усны зардалд 2,000.0 мянга, шатахууны зардалд 10,000.0 мянган төгрөг батлагдаж “РМВ” ХХК-тай дулаанаар хангах гэрээ, “НИК” ХХК-тай шатахууны гэрээ, “Чандмань-Баянхонгор” ХК-тай цэвэр, бохир усаар хангах гэрээ, “Баянхонгор-Эрчим хүч” ЦТХХК-тай цахилгаан, эрчим хүчээр хангах гэрээг тус тус байгуулж ажилласан байна.

Тус байгууллага нь цэвэр, бохир усны зарцуулалтыг тоолуурын заалтаар тооцож төлбөр төлсөн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баянхонгор аймгийн Байгаль орчны газар нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Н.Батчимэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Алтантуяа, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор аймгийн Байгаль орчны газар нь 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 493 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2024 оны батлагдсан төсөв 1,626,231.4 мянган төгрөгийн дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны батлагдсан төсөв 1,626,231.4 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 16,262.3 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 65 хувиар буюу 10,570.5

мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Ан амьтны менежментийн төлөвлөгөөний зардлаас 2,224.5 мянган төгрөгийг 12 албан хаагчийг шагнахад зарцуулсан нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-т “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно”, 15.1.3-т “хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох” гэсэн заалтыг зөрчсөн байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант онд шилэн дансны цахим хуудаст 87 тушаал, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 2,508,378.8 мянган төгрөгийн орлогын 42 гүйлгээ, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 542,203.7 мянган төгрөгийн 40 гүйлгээг бүрэн мэдээлсэн байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Тайлант хугацаанд завсрын аудит хийгээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны аудитаар нийт 3,698.7 мянган төгрөгийн 3 зөрчил илэрч, зөрчлийг арилгах, зөрчил давтан гаргахгүй байх 3 албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлэн даргын 2024.04.12-ны өдрийн 138 тоот албан бичгээр ТАБ-д хариуг ирүүлж хэрэгжилтийг FAS системд оруулсан байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Байхгүй

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 1,732.1 мянган төгрөгийн 1 зөрчил¹ илэрснээс, 1,732.1 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоосон.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлийн 1,732.1 мянган төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 8,838.4 мянган төгрөгөөр бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

5.1 Төлбөрийн акт

5.1.1. Ан амьтны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх зардлаас даргын 2024.12.17-ны өдрийн "Шагнаж урамшуулах тухай" Б/71 дүгээр тушаалаар 1,732,050 төгрөгийг зориулалт бусаар зарцуулж 11 албан хаагчийг шагнасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь “батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-т “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно”, 15.1.3-т “хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Тайлант хугацаанд зориулалт бусаар зарцуулсан 1,732.1 мянган төгрөгийг дарга, нягтлан бодогч нараар төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

Аудитаар өгсөн шийдвэрийн хэрэгжилтийг нотлох баримтын хамт төрийн аудитын байгууллагад 2025 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

(мянган төгрөг)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох албан шаардлага	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Ан амьтны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх зардлаас даргын 2024.12.17-ны өдрийн "Шагнаж урамшуулах тухай" Б/71 дүгээр тушаалаар 1,732,050 төгрөгийг зориулалт бусаар зарцуулж 11 албан хаагчийг шагнасан байна.	1	1,732.1	1	1,732.1	-	-	-	-
Дүн	1	1,732.1	1	1,732.1	-	-	-	-

-----oOo-----